

ЗАХИРЛЫН МЭДЭЭЛЭЛ

Сайн Байцгаана уу,

Хаврын дулаахан цаг агаарт та бүхэн гэр бүлээрээ цагийг хамт өнгөрөөж байгаа гэдэгт би итгэлтэй байна. ОУДС-ийн хамт олон бид багш, сурагчид, эцэг эхчүүдийг оролцуулсан олон арга хэмжээ зохион байгуулж байна. Пүрэв гарагт 4-р ангийн сурагчид өдөрлөг зохиож дэлхийн ард түмэнд хандаж хэлсэн Гандигийн сургаалийн талаар бидэнтэй хуваалцлаа. Энэ жүжигчилсэн тоглолтыг амжилттай хийсэн Mrs. D'Souza багшийн сурагчдад болон өдөрлөгийн ажиллагаанд оролцсон бүх хүмүүст баярлалаа.

5-р ангийн сурагчид СУИС-ийн дуулаачийн ангийн оюутан Сүнгэрэлийн сургалтын төлбөрт хандив цуглуулахаар багш нарын жинс өмсөх өдрийг зохион байгууллаа. Энэ хандивын арга хэмжээг дэмжиж багш нар Пүрэв гарагт жинс өмсөж төлбөр төлсөн юм. Энэ хандив цуглуулах ажилд жинс өмсөж төлбөр төлсөн болон жинс өмсөөгүй ч хандив өргөсөн бүх хүмүүст баярлалаа.

Баасан гарагийн орой болох урлагийн авъяастнуудын тоглолт, үзэсгэлэнг амжилттай зохион байгуулахаар ажиллаж байгаа комиссийн гишүүн багш Ms. Leong, Ms. Sudra, Mrs. Berg, Ms. Wiggins, Mrs. Jenner нарт талархал илэрхийлье.

Амралтын өдрүүдэд болсон Стратеги төлөвлөлтийн сургалтанд оролцсон багш, сурагчид, эцэг эхчүүд, удирдах зөвлөлийн гишүүдэд баярлалаа. Энэ хоёр хоногийн сургалтын үеэр бид олон зүйл хийж амжууллаа. Энэ сургалт сургуулийн цаашдын өсөлт, хөгжилтөнд тодорхой хувь нэмэр оруулах болно.

Захирал Greg Rayl

ХУАНЛИД ТЭМДЭГЛЭХ ӨДРҮҮД:

Өнөө орой болох авъяастнуудын тоглолтын үеэр бид та бүхэнтэй уулзана гэж найдаж байна. 6:45-д ЭББ-ийн жигнэмэгийн худалдаа, 7 цагаас үзэсгэлэн үзэх, 7:30-д сурагчдын тоглолт биеийн тамирын заланд болно.

5 сарын 27	Төгөлдөр хуурын дугуйлангийн сурагчдын концерт 6:30
5 сарын 28	Төгсөлтийн Баяр
6 сарын 1	Хүүхдийн Баяр-Нийтээр амрах баярын өдөр
6 сарын 2-4	4-р ангийн Кемп аялал
6 сарын 8	5-р ангийн Үзэсгэлэн
6 сарын 10-11	3-р ангийн Кемп аялал
6 сарын 10-12	5-р ангийн Кемп аялал

2010-2011 оны хичээлийн жилийн элсэлтийн талаар

Төлбөрийн болон Элсэлтийн мэдээллийн хуудсуудыг бөглөж бидэнд ирүүлсэн бүх эцэг эхчүүддээ баярлалаа. Капитал фондын хураамж болон элсэлтийн төлбөрийг 2010 оны 6 сарын 1-ний дотор төлж хүүхдийнхээ орон тоог баталгаажуулна уу.

2010-2011 оны хичээлийн жилийн сургалтын төлбөрийн нэхэмжлэлийг та бүхэнд удахгүй илгээх болно. Та бүхэн хүүхдийнхээ сургалтын төлбөрийг 8-1-ний дотор хугацаанд нь төлөөрэй.

БАГА СУРГУУЛИЙН МЭДЭЭ

4-р ангийн сурагчид мод тарьялаа.

Бидэнд тарих мод бэлэглэсэн ноён Анандбазар танд баярлалаа. 4-р ангийн сурагчид бид таны бэлэглэсэн бутнуудыг сургуулийнхаа өмнөх талбайд суулгасан. Эдгээр бутнууд сайхан ургана гэж би бодож байна. Alek

Бидэнд мод бэлэглэсэнд баярлалаа. Байгаль орчны төлөө анхаарал тавих нь сайн хэрэг гэж би бодож байна. Ногоон мод байгаль орчинд тустай учраас би эдгээр моднуудыг тарихдаа их баяртай байсан. Байгаль орчиндоо хайртай тан шиг хүмүүс олон байгаа гэдэгт би итгэлтэй байна. Da Hyun
Бидэнд мод бэлэглэсэн ноён Анандбазар танд баярлалаа. Эдгээр моднуудыг суулгаад дөнгөж нэг сар

болж байгаа ч гэсэн бид ургаж байгаа мөчрүүдийг нь одоо харж байна. Enkhbileg

Бидэнд мод бэлэглэсэнд баярлалаа. Эдгээр моднууд манай сургуулийн орчин тойронг улам гоё болгож чимэглэх болно. Тан шиг хүмүүс олон байгаасай гэж би хүсэж байна. Ha Ryung

Бидэнд тарих мод бэлэглэсэн ноён Анандбазар танд баярлалаа. Бид эдгээр моднуудыг суулгахдаа баяртай байсан. Мод сайн ургахад сайн хөрс хэрэгтэй гэдгийг би ойлгосон. Cassie

5-р ангийн сурагчдаас

Сайн байцгаана уу. Бид 5-р ангийн сурагчид байна. Асрамжийн газрын хүүхдүүдэд хамгийн чухал хэрэгтэй зүйл юу байдгийг бид олж мэдэхийг хүссэн. Тэдэнд ямар нэгэн зүйл хэрэгтэй биш харин тэд юу хүсэж мөрөөдөж байдгийг бид олж мэдсэн. Тэдэнд хамт тоглох хүүхдүүд хэрэгтэй байдаг учраас бид сургуулийнхаа сурагчдыг Баян Зүрхийн асрамжийн газар луу аваачиж асрамжийн хүүхдүүдтэй хамт тоглуулж байна. 3-р ангийн сурагчид Даваа гарагт, 4F ангийн сурагчид Лхагва гарагт тэдэнтэй очиж тоглосон. Хүүхдүүд хамтдаа тоглож их хөгжилтэй байсан. Бид цаас, өнгийн харандаа, леги тоглоомууд авч очсон. Хүүхдүүд энд тэндгүй тоглож үсэрч харайж хөгжөөнтэй байсан. Тэд цаасан онгоц хөөргөж, зурсан зургаа бие биендээ дурсгасан. Бид энэ арга хэмжээг цаашид үргэлжлүүлж асрамжийн газар очиж эдгээр хүүхдүүдтэй тоглох болно. Ирэх Даваа гарагт 2-р ангийн сурагчид, Лхагва гарагт 4D ангийн сурагчид асрамжийн газрын хүүхдүүдтэй очиж цуг тоглоно. Асрамжийн газрын хүүхдүүд биднээс өөрцгүй бидний нэгэн адил хэн нэгэнтэй тоглохыг л хүсч байдаг болохыг бид олж мэдсэн.

ДУНД СУРГУУЛИЙН МЭДЭЭ

Өнгөрсөн амралтын өдрүүдэд зохиогдсон стратеги төлөвлөлтийн сургалт амжилттай болж өнгөрлөө. Энэ сургалтанд оролцож өөрсдийн санаа бодлоо хуваалцаж, амралтын цагаа энэ ажилд зориулсан багш нартаа талархал илэрхийлье. Манай хамт олноос дараах багш нар энэ сургалтанд оролцсон: 3-р ангийн туслах багш Ариунцэцэг, 1-р ангийн туслах багш Хонгорзул, ресепшин Халиунаа, багш Dave Chilton, Margriet Faber, Justino D' Souza, Shelly D' Souza, Hilde Berg, Paul Laws, Wendy Silberberg, Liz Covington. Chris Thompson, Захирал Greg Rayl, Дэд Захирал Туул Арилдий, Бага Сургуулийн Эрхлэгч Jan Wiggins, Дунд Сургуулийн Эрхлэгч Betsy Hanselmann.

Энэ сургалтыг амжилттай зохион байгуулахад тусалсан оффисийн ажилтан Энхээ, Бадмаа, Ууганбаяр, Баасанхүү, Намхай, үйлчилгээний ажилтан Мөнхцэцэг, Дариа нарт талархал илэрхийлье. Багаараа хүн бүр нэгдэж ажилласнаар энэ сургалт амжилттай зохион байгуулагдсан. Та бүхэнд баярлалаа.

Залуу аялагчдын Клубийн гишүүд энэ амралтын өдрүүдэд бас аялалд гарах гэж байна. Mr. Chilton, Mr. Berg нарын удирдан зохион байгуулж байгаа энэ аялалд оролцох боломж та бүхэнд байна. Охидууд бас энэ аялалд оролцвол сайн байна. Охидын хөл бөмбөгийн баг тамирчид Бямба гарагт бэлтгэлээ үргэлжлүүлэн хийж байна.

Сурагчид та бүхэн сайн унтаж амарч зөв зохистой хооллож байх нь чухал. Ингэснээр уураг тархи сайн ажиллаж амжилттай сайн суралцах боломжтой.

Та бүхэн өнөө орой зохиогдох авьяастнуудын тоглолтонд хүрэлцэн ирэхээр хуанлидаа тэмдэглэсэн байгаа гэдэгт итгэлтэй байна. Ирэх амралтын өдрүүдэд АСАМIS-н тэмцээнд оролцогчдод зориулсан хүлээн авалт болон төгсөлтийн баяр болно. Та бүхэнтэй энэ өдрүүдэд уулзана гэж найдаж байна.

Дунд Сургуулийн Эрхлэгч Betsy Hanselmann

2010 оны 5 сарын 28-ны Баасан гарагт сурагчдын зөвлөл Зуны Өдөр арга хэмжээ зохион байгуулна. Багш сурагчид энэ өдөр зуны хувцас буюу углааш, зуны даашинз, богино өмд өмсөж болно. Гэхдээ сургуулийн орчинд тохирсон зуны хувцас өмсөх ёстойгоо санаарай. Зуны өдрийг сайхан өнгөрүүлээрэй. Баярлалаа.

Сурагчдын Зөвлөл